



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/51.

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалтууд, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Архангай аймгийн Өгийнуур сумын Өгийнуур, Завхан аймгийн Идэр сумын Ногоон нуур, Тэлмэн сумын Идэрийн гол, Тэлмэн нуур, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Дэлгэрмөрөн, Цагаан-Уул сумын Тунамал нуур, Тариалан сумын Сэлэнгэ мөрөн зэрэг газруудад шумуулаар дамжих халдварын байгалийн голомтын тандалт судалгаа"-ны ажлыг удирдамжийн дагуу чанартай гүйцэтгэж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны халдвар судлаач (Л.Роломжав)-д, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга (Х.Ариунболд)-д тус тус үүрэг болгосугай.

2. Тандалт судалгааны зардал болох 5.128.050 (Таван сая нэг зуун хорин найман мянга тавь) төгрөгийг томилолт, тээвэр, шатахуун, холбогдох зардлаас тооцож гаргахыг Санхүү, хангамж, нөөцийн албаны Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны алба (У.Нямжаргал)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР